

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

**Аудитын код: БУА-2025/108/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342495 Цахим хаяг: [enkhturb@audit.gov.mn](mailto:enkhturb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.03 № 18  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ШҮҮХИЙН  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.ТӨГСБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт баривчлагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдэд зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж авахад 3,000.0 мянган төгрөг, 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 15 дугаар тогтоолоор цагдан хорих байрны хамгаалалтын хашааг засварлах, хяналтын камер нэмж байршуулахад 7,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Тайлант онд цалингийн сангийн хэмнэгдсэн төсвөөс Ахмадын сан байгуулан ажиллуулах журын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтын дагуу 6,331.7 мянган төгрөгийн ахмадын санд төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант

006020038

үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН  
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.ЭНХЦООДОЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	80815309.31	62562716.53
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1227388802.27	1528630497.62
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	1308204111.58	1591193214.15
Нийт өр төлбөрийн дүн	5654832.19	457150.00
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1302549279.39	1590736064.15
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	1308204111.58	1591193214.15
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	1020028885.96	1728131032.01
Үйл ажиллагааны зардлын дүн	1058823627.23	1439944247.25
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	-38794741.27	288186784.76
Үйл ажиллагааны бус үр дүн	87021.01	767800.00
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	-38794741.27	288186784.76
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,072,727.16	1,302,549,279.39
Тайлант оны үр дүн		288,186,784.76
<b>Эцсийн үлдэгдэл</b>	337,072,727.16	1,590,736,064.15
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1026127723.09	1368589719.67
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1016039089.69	1371639800.00
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	10088633.40	-3050080.33
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>		
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	10088633.40	-3050080.33
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10,434,633.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,384,553.07
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>		1370872000.00
Урсгал зардал		1370872000.00
Хөрөнгийн зардал		
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>		
Улсын төсвөөс санхүүжих		1326148400.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		26109550.00

### Гурав.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 457.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 457.1 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч зөвлөмж өглөө.

1. Хоол хүнсний зардлын 312.9 мянган төгрөгийг зөрүүтэй тусгасныг засаж тусгуулсан.

#### 3.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

#### 3.2 Албан шаардлага бичигдээгүй

#### 3.3 Зөвлөмж

1. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ялтны нэрийн дансанд олгогдоогүй үлдсэн 457.1 мянган төгрөгийн өглөг үүссэн.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ялтаны нэрийн дансанд олгогдоогүй үлдсэн өглөг	1	457.1							1	457.1				
Дүн	1	457.1							1	457.1				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						